

Монгол Улс

Судалгаа: Стратеги

Дэлхийн хамгийн залууд тооцогдож буй Лаосын хөрөнгийн бирж Монголтой өрсөлдөх шинэ тоглогч болох цаг ойрхон байна

Лаосын үнэт цаасны бирж- шинэ зах зээл. 2011 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр ЛАОСЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ (ЛҮЦБ) нь эрчим хүчний EDL Женерэйшн (EDL), Banque Pour Le Commerce Exterieur Lao (BCEL) банк гэсэн төрийн өмчит хоёр компанийн хувьцааны арилжаагаар нээлтээ хийв. Энэхүү хоёр компанийн үнэт цаасаа анхдагч зах зээл дээр гаргах үйл ажиллагаа амжилттай явагдаж, нийт **140 сая ам.долларын хөрөнгө босгожээ**. EDL-ийн 25%, BCEL-ийн 15%-ийн олон нийтэд арилжаалсан нь дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг ихээхэн татаж, нийт гаргасан хувьцааны тооноос худалдан авах захиалгын хэмжээ давсан байна. EDL-ийн хувьцааг 20 гаруй улсын хөрөнгө оруулагч худалдан авсан байна. Лаосын энэ хоёр компанийн олон нийтэд хувьцаагаа санал болгож төвлөрүүлсэн хөрөнгө нь Монголын компаниуд Монголын Хөрөнгийн Бирж (МХБ)-ийн дээрээс татан **төвлөрүүлсэн нийт хөрөнгийн (50 сая ам.доллар) дүнгээс гурав дахин их байгаа юм.**

ЛҮЦБ шинээр бүртгүүлсэн компанийн тоогоороо МХБ-ийг гүйцэх магадлалтай байна. Тус улсын үндэсний компаниуд ирэх таван жилд хувьцаа болон бондын анхдагч зах зээлийн арилжаагаар (энэ жил хийгдэх 2-3 IPO-г оролцуулан) **8 тэрбум ам.долларын хөрөнгө** босгоно гэсэн хүлээлт Лаосын Засгийн газарт байна. Лаос Улс нь Азид хамгийн залуу бирж байгуулж хөрөнгө босгох өндөр зорилго тависан байгаа нь **нэн шинэ зах зээл рүү чиглэсэн сангуудын хөрөнгийг татах тал дээр Монголтой өрсөлдөх шинэ тоглогч болох төлөвтэй байна.** МХБ сүүлийн 10 жилийн туршид дэлхийн хамгийн жижиг биржид тооцогдож байсан бол өнөөдөр **600 сая ам.долларын** зах зээлийн үнэлгээгээрээ ЛҮЦБ дэлхийн хамгийн жижиг биржид тооцогдох болов. МХБ-д шинээр олон нийтэд хувьцаагаа санал болгох компаниудын үйл ажиллагаа хоёр жилийн турш зогсонги байгаа нь цаашид үргэлжилсээр байвал ирэх хоёр жилийн хугацаанд ЛҮЦБ зэрэг шинэ оролцогчид зах зээлийн үнэлгээ, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээгээрээ 20 жилийн түүхтэй МХБ-ийг түрүүлэх магадлалтай байна. Олон талаараа Монголтой төстэй, байгалийн их баялагтай Лаос нь Вьетнам, Тайланд зэрэг Азийн бусад орны амжилтыг давтах нь гарцаагүй юм. “Нэн шинэ зах зээлийн нэг болох Лаос бидний анхаарлыг онцгой татаж байна” гэж Templeton Emerging Markets Сангийн Марк Мобиус тэмдэглэсэн байна.

Дэлхийн хамгийн өндөр өсөлттэй зах зээл. Анхны өдрийн арилжаагаар BCEL-ийн хувьцааны ханш 45%, EDL-ийн хувьцааны ханш 9,3%-иар тус тус өссөн байна. Байгуулагдсан өдрөөсөө ЛҮЦБ-ийн нэгдсэн индекс 15%-ийн өсөлт үзүүлж, оны эхэнтэй харьцуулсан гүйцэтгэлээрээ дэлхийн хамгийн өндөр өсөлттэй зах зээл боллоо. 2010 оны хамгийн өндөр өсөлттэй зах зээл нь МХБ (+135%) болсон билээ. Тэгвэл ЛҮЦБ-д шинэ компаниуд бүртгүүлэх үйл ажиллагаа идэвхтэй явагдаж, тэдэнд хөрөнгө оруулах сонирхол бүс нутгийн (Тайланд, Вьетнам, Хятад, Солонгос) болон Templeton Frontier Markets Fund зэрэг хөрөнгө оруулагчийн дунд их байгаа нь энэ онд хамгийн өндөр өсөлттэй зах зээл болох нь гэсэн хүлээлтийг бидэнд бий болгож байна.

Боловсронгүй дэд бүтэц, эрх зүйн орчин. Дээрх компаниуд гадны хөрөнгө оруулагчдыг анхаарлыг татаж, амжилттай IPO хийж чадсан нь хувьцааны арилжааны дэд бүтэц боловсронгуй байсантай холбоотой гэж бид үзэж байна. **Солонгосын бирж** ЛҮЦБ-ийн арилжааны системд хөрөнгө оруулж, зохицуулах байгууллагуудад цогц үйл ажиллагаатай (үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгалалтын систем) хөрөнгийн зах зээл бий болгоход туслалцаа үзүүлэн **ЛҮЦБ-ийн 49%-ийг эзэмших болсон юм.** Мөн Солонгосын бирж Лаосын Засгийн газарт хөрөнгийн зах зээлийн зохистой эрх зүйн орчныг бий болгох, цогц үйл ажиллагаа бүхий хөрөнгийн бирж байгуулах зэрэг ажилд сүүлийн гурван жилийн турш тусалж иржээ.

МХБ-ийн шинэчлэлт. Лаос хөрөнгийн биржээ амжилттай байгуулан хөгжүүлж байгаа нь Монголын хөрөнгийн биржийн хувьд чухал жишээ болж байна. Монголын компаниудад нэн чухал шаардлагатай байгаа гадны хөрөнгө оруулалтыг өрсөлдөн татахын тулд Монгол Улс **ойрын хугацаанд хөрөнгийн бирждээ үр дүнтэй өөрчлөлт хийх хэрэгтэй** гэж бид үзэж байна. Хэдийгээр МХБ хурдацтай өсөх бололцоотой боловч тулгамдсан асуудлууд (шинэ IPO гарахгүй байгаа, бувьцааны бүртгэл хадгалалттай холбоотой шийдвэрлэх асуудал, давхар бүртгэлт болон бадгалалтын сертификат гаргах зэрэг ажиллагааг эрх зүйн хувьд зохицуулаагүй) байсаар байгаа юм. Хамгийн харамсалтай нь Монголын томоохон компаниуд МХБ-ээс илүүтэйгээр гадаадын зах зээл рүү хандаж, санхүүгийн эх үүсвэрээ бүрдүүлж байна. Мөн Лаостай харьцуулахад Монголын банк, эрчим хүч, дэд бүтцийн нэг ч компани МХБ-д хувьцаагаа бүртгүүлээгүй байгаа. МХБ шинэчлэгдсэнээр амжилттай хөгжиж, ЛҮЦБ зэрэг тоглогч нартай өрсөлдөн, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалтыг улам ихээр татаж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Судалгаа

2011 оны нэгдүгээр сарын 11

Сардор Кошназаров
Судалгааны албаны дарга
sardor.koshnazarov@eurasiac.com

ЛаХБ-ийн нээлтийн ажиллагаа



Лаосын дэд ерөнхий сайд Сомсават Ленгсавад, Солонгосын хөрөнгийн биржийн гүйцэтгэх захирал Ким Бонг-Сoo нар ЛҮЦБ-ийн нээлтийн арга хэмжээний үер улаан тууз хайчилж байгаа нь, Виентiane, Лаос

Азийн хөрөнгийн бирж

Бирж	Бүртгэлтэй компанийн тоо	Зах зээлийн үнэлгээ, тэрбум ам.доллар
Тайланд	554	270.0
Вьетнам	760	38.5
Монгол	313	1.1
Лаос	2	0.6

Эх сурвалж: Блүүмберг, МХБ

Монгол ба Лаос: Харилцан адил талууд

	Лаос	Монгол
Газар нутаг, км ²	236,800	1,564,116
Хүн амын тоо	6.44сая	2.75сая
Шашин	буддизм	буддизм
ДНБ (2010e)	\$6.3тэрб	\$6.6тэрб
Нэг хүнд ноогдох ДНБ (2010e)	\$984	\$2111
Голлох салбар	Эрчим хүч, ашигт малтмал	Ашигт малтмал
Экспорт (2009)	\$1.1 тэрб	\$1.9 тэрб
БНХАУ-тай хил залгаа байдал	тийм	тийм
Гол экспортын бүтээгдэхүүн	Эрчим хүч, зэс, алт	Нүүрс, зэс, төмрийн хүдэр, алт
Гадаад худалдааны түншүүд	Тайланд, БНХАУ, Вьетнам	БНХАУ, ОХУ, БНСУ

Эх сурвалж: ОУВС, ДБ, УСХ



Буддын лам ЛҮЦБ дээр хувьцаа худалдан авах захиалга өгч байгаа нь